

“ДУУРЬ, БҮЖГИЙН ЭРДМИЙН ТЕАТРЫН ТАЙЗ, ДУУ АВИАНЫ ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН ШИНЭЧЛЭЛ ТӨСӨЛ”-ИЙГ ХЭРЭГЖҮҮЛСНЭЭР МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСАГ, ТУХАЙН САЛБАРТ ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ, ҮР ДАГАВРЫН ТАЛААРХ ДҮН ШИНЖИЛГЭЭ

1. Өнөөгийн нөхцөл байдал, төсөл хэрэгжүүлэх хэрэгцээ, шаардлага

Дуурь, бүжгийн эрдмийн театрын барилга 1950 онд баригдсан бөгөөд тайзны тоног төхөөрөмж, гэрэл, тайзны эргэдэг тойрог болон бусад тоног төхөөрөмжүүд нь 1950-1960 онд Зөвлөлт Холбоот Улс (хуучнаар)-д үйлдвэрлэсэн байдаг. Сүүлийн жилүүдэд тайзны суурь доод эд ангийн механизм ажиллахгүй, засвар хийх боломжгүй, сэлбэг олдохгүй болсноос шалтгаалан тоглолтын үед тайзны ажиллагсад гараар буюу механикаар түрж, хөших зэргээр ажиллуулж, туухай, олс, арааг хүний хөдөлмөрөөр эргүүлж тайзыг ашиглаж байсан. Өнөөдрийн байдлаар тайз эргэхгүй зогссоноос гадна байгууллагын ажиллагсдын ажлын байрны аюулгүй байдалд эрсдэл үүсэх нөхцөл үүссэн.

Үүнээс шалтгаалан театрын урын санд байгаа уран бүтээлүүд тоглогдохгүй болж байна. Мөн тус театрт концерт, тоглолт хийхэд дуу, гэрэл, тайзны хүртээмж шаардлага хангахгүйн улмаас зарим тохиолдолд нэмэлт тоног төхөөрөмжүүдийг авчирч ашиглаж байгаа нь дуурийн театрын дуу чимээний үндсэн шинжийг алдагдуулж, үзэгч, хэрэглэгчдийн хүлээлтэд нийцсэн соёл, урлагийн үйлчилгээ үзүүлэхэд хүндрэл учирч байна.

Үндэслэл

“Алсын хараа -2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны 1.1.8-д “Үндэсний сонгодог урлагийн дэг сургууль буюу заах арга зүйг магадлан итгэмжлүүлж баталгаажуулан монголын үндэсний сонгодог урлаг хэмээн дэлхийд танигдах бүтээлийг дэмжинэ” гэж, 1.1.19-д “Соёл урлагийг хүүхэд, залуучууд, бүх нийтэд түгээн дэлгэрүүлэхэд шаардлагатай театр, чуулга, соёлын ордны барилгыг шинээр барьж, тоног төхөөрөмжийг шинэчилнэ” гэж, 9.2.33-т “Хотын барилга байгууламжийг паспортжуулах, тэдгээрийн чанар, насжилтыг тодорхойлох, газар хөдлөлтийн үед тэсвэрлэх чадварт хянан баталгаажуулалт хийх, эрсдэлтэй байгууламжийг хүчитгэх, эсвэл буулгаж шинэчлэн барилгажуулах ажлыг зохион байгуулна” гэж, Монгол Улсын Засгийн газрын 2024–2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.3.5.8-д “Монголын нүүдлийн соёл, орон нутгийн онцлогт тохирсон бүтээгдэхүүн, үйлчилгээ, брэндийг хөгжүүлж, үйлчилгээний стандартыг олон улсын жишигт нийцүүлнэ” гэж тус тус заасан.

2. Салбарын болон эдийн засгийн үр ашиг

Дуурь, бүжгийн эрдмийн театрын тайз, гэрлийн тоног төхөөрөмж болон дуу авианы тоног төхөөрөмж, үзэгчийн суудлыг бүрэн шинэчилснээр Монгол Улс анх удаа дэлхийн стандартын болон аюулгүй байдлын чанарын шаардлагыг хангасан мэргэжлийн өндөр түвшний театрын тайз, гэрэлтүүлэг, дуу авианы төхөөрөмжтэй болоод зогсохгүй чадварлаг хүний нөөцтэй болно.

Ингэснээр жилд давтагдсан тоогоор 96 удаа тоглодог байсан тоглолтын тоо 126 болж, 1 тэрбум 200 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлдэг байсан орлого 30 хувиар нэмэгдэх, олон улсын чанартай тоглолт, арга хэмжээний тоо жилдээ 50 болж нэмэгдэх, дэлхийн нэр хүндтэй уран бүтээлч, уран бүтээлийг өөрийн тайзнаа тоглуулах боломж бүрдэж, тус байгууллагын санд байгаа уран бүтээлийн ашиглалт, эргэлт сайжирч, үзэгчдийн соёл, урлагийн хүртээмж нэмэгдэх чухал ач холбогдолтой.

Мөн энэхүү төслийг хэрэгжүүлснээр олон улсын хамтын ажиллагааг өргөжүүлэх томоохон боломжийг нээж, хамтарсан бүтээл туурвих, уран бүтээлчдийн солилцоог дэмжих, дэлхийн тэргүүлэх байгууллагуудтай түншлэл тогтоох боломжтой болно гэж үзэж байгаа бөгөөд дотоодын уран бүтээлчдийн ур чадварыг хөгжүүлэх, Монголын соёлын салбарын урт хугацааны тогтвортой байдлыг хангахад шууд хувь нэмэр оруулах юм.

---oOo---